

Та бэлэн үү??

2024 оны 9-р сар



1-р зураг. Тулаанд бэлэн хүлэг баатар



2-р зураг. Ээлжийн ажилдаа бэлэн ажилтан

XVI зууны хүлэг баатар тулаандаа хэрхэн бэлддэгийг киноноос харж байсан л биз дээ. Сэлмээ ирлэж, бамбайгаа шалгаж, хуяг дуулгаа өмсөж үздэг шүү дээ. Удирдагч нь тулааны төлөвлөгөөгөө тайлбарлаж, бүх хүн байраа эзлээд, тулаан эхлэхийг хүлээдэг. Зарим кинон дээр цэргүүд хүндээр шархдаж, эсвэл амиа ч алдаж болохоо ухамсарлаж, тулаанд бэлэн болсон байдаг.

Харин та ажлаа эхлэхэд бэлэн үү? Ажилтан ээлж эхлэхэд ХХХ буюу хамгаалалтын шил, галд тэсвэртэй хувцас, гутал, дуулгаа өмсөж бэлддэг. Мөн хэмжих багажаа тохируулж, хийн хяналтын төхөөрөмжөө асаах нь бий. Багийн ахлагч нар үйлдвэрлэлийн төлөвлөгөө, шалгах ёстой зүйлсийн жагсаалт гаргаж, ээлж хүлээлцэх, ээлж эхлэх хурлаар ажилчдаа танилцуулдаг.

Үйлдвэрийн процесс, тоног төхөөрөмжийн аюул эрсдэл бол бидний дайсан, харин дайснаа дарах нь бидний тулаан юм. Бид ажлын талбайн үзлэг хийх, гэмтэлтэй тоног төхөөрөмжийг шалгах, засварлахдаа өдөр бүр тулаанд орж байдаг. Бид ажилдаа эртний хүлэг баатрууд шиг чин сэтгэлээсээ хандаж чадаж байна уу. Та ХХ-ээ өмсөж байхдаа өнөөдөр танд тулгарах аюул эрсдэлийн талаар боддог уу?

Та мэдэх үү?

- Төлөвлөх нь ажлаа аюулгүй, амжилттай гүйцэтгэхийн үндэс.
- Ээлж хүлээлцэхдээ ээлжээсээ бууж байгаа болон ээлжээ эхэлж байгаа ажилчид нүүр нүүрээ харан хэлэлцэх нь үр дүнтэй.
- Ээлж хүлээлцэх хурлыг үр дүнтэй байлгахын тулд:
 - ✓ Үйлдвэрлэлийн процесс нэг бүрийн төлөв байдал
 - ✓ Процессын доголдол, үйлдвэрлэлийн тулгамдсан асуудал
 - ✓ Зогсоосон, засварт орсон тоног төхөөрөмж
 - ✓ Тойруулсан, зогсоосон тоног төхөөрөмж, хяналт
 - ✓ Гэрээт байгууллагын гүйцэтгэж буй ажил
 - ✓ Дараагийн ээлжид үргэлжлэн хийхээр зөвшөөрөл авсан ажил
 - ✓ Үйлдвэрийн өөр хэсгээс тухайн хэсэгт ирсэн зочид, ажилчид
 - ✓ Тухайн хэсгийн бүртгэл, тэмдэглэлийг хэлэлцэнэ.
- Хэлэлцэж буй асуудлыг бодитоор харахын тулд ажлын талбайд биечлэн очих шаардлагатай байж болно.
- Зарим компани ээлж хүлээлцэх хурлаар хэлэлцэх бүх асуудлыг багтаасан жагсаалт, маягт ашигладаг.

Та юу хийх ёстой вэ?

- Хэлэлцэх асуудлыг бүрэн ойлгож авахын тулд, хяналтын өрөө, ээлж хүлээлцэх хэсэгт цагтаа ирэх.
- Бүртгэл, тэмдэглэлийг анхааралтай унших. Зөвхөн асуудлыг түүж харах биш, тухайн хэсгийн нөхцөл байдлыг бүрэн ойлгож авах.
- Ээлж хүлээлцэх маягт, журмын дагуу бүх асуудал, санаа зовоосон зүйлсийг нэг бүрчлэн хэлэлцэх.
- Үйлдвэрлэлийн процессын одоогийн нөхцөл байдлыг ойлгож авахын тулд асуулт асуух.
- Ээлж хүлээлцэх хуралд идэвхтэй оролцох. Таны амь амьдрал энэ хурлаас шалтгаалах юм шиг анхааралтай сонс. Шалтгаалж ч болзошгүй.
- Зөвшөөрлийг дараагийн ээлжид дахин олгох шаардлагатай бол зөвшөөрөл өгөх, гарын үсэг зурахын өмнө биечлэн шалга. Нөхцөл байдал өөрчлөгдсөн байж болзошгүй.

Ажлаа эхлэхдээ сорилт бэрхшээлтэй нүүр тулахад бэлэн бай!